



ХОРИХ ЯЛ ЭДЛЭЭД СУЛЛАГДСАН ЗАРИМ ЭТГЭЭДЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАВИХ ЗАХИРГААНЫ ХЯНАЛТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь “Хорих ял эдлээд суллагдсан зарим этгээдэд цагдаагийн байгууллагаас тавих захиргааны хяналт” сэдвийн хүрээнд Тунгаамал төв ТББ-д мониторинг хийх тэтгэлэг олгосон билээ. Тус мониторингийн хүрээнд хорих ял эдлээд суллагдсан хүмүүст тавьж буй хяналтын өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт, тус хяналтын үр нөлөөг үнэлэхийн зэрэгцээ бусад улсын туршлага судлахыг зорилоо.

Мониторингийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

МОНИТОРИНГИЙН ДҮН

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт Эрүүгийн хуулийн 6.12, 6.13 дугаар зүйлд зааснаар хугацаанаас өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн, 12.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 13.1, 13.3, 15.5, 19.9, 21.2 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, таван жилээс дээш хугацаагаар хорих ял эдэлсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтоохоор зохицуулсан байна. Тус хяналтыг хэрэгжүүлэх процесс ажиллагааг Цагдаагийн ерөнхий газрын даргын 1998 оны 194 дүгээр тушаалаар баталсан журмаар тодорхойлжээ.
- Өмнө үйлчилж байсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд “хорих ял эдлээд суллагдсан этгээдэд захиргааны хяналт тогтооно” гэсний дагуу нэг заалтаар зохицуулж байсан бол шинэ хуулиар бүтэн бүлгээр, илүү нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, хяналтад байгаа хүнийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хяналтад байгаа хүний эерэг зан, төлөв байдлаас хамааран урамшуулах буюу цагдаагийн байгууллага, алба хаагч хяналтад байгаа хүнийг зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд дуудахгүй байх, энэ хуулийн 45.1.2, 45.1.4, 45.1.5-д заасан хугацаа, давтамжийг хуульд зааснаас сунгаж тогтоох болон урьд тогтоосон зарим үүрэг, хориглолт, хязгаарлалтыг цуцлах

байдлаар хэрэгжүүлнэ. Хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр оролцуулж болно гэх зэрэг эерэг зохицуулалт тусжээ.

- Хэдий хуулийн зохицуулалт сайжирсан ч хяналт тогтоох хүний талаарх мэдээллийг хорих байгууллага суллагдахаас нь 30 хоногийн өмнө байнга оршин суух газрын цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүргээ хангалттай биелүүлэхгүй байна. Тухайлбал, хорих байгууллага суллагдах хүний тодорхойлолтыг хуульд заасан хугацаанд бараг ирүүлдэггүй, ирүүлсэн ч хяналтад авагдах хүнийг суллагдсанаас хойш ирүүлж байгаа нь бэрхшээл учруулж, хяналт тавивал зохих бүх хүнийг хяналтад хамруулж чадахгүйд хүрч байна.
- Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллага нь захиргааны хяналтад авагдвал зохих хэдэн хүн суллагдсанаас хэдэд нь зохих ёсоор захиргааны хяналт тогтоосон талаар нэгдсэн бүртгэлгүй, түүнд тавьдаг дотоод хяналт сул байгаа нь мониторингийн явцад тодорхой боллоо.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ял эдлүүлэх газрын даргын тушаал, заавар, эрх зүйн актыг судалж үзэхэд хорих ял эдлээд суллагдсаны дараа хяналт тогтоогдвол зохих хүний тодорхойлолтыг ямар субъект гаргаж, түүнд хэрхэн хяналт тавих талаар зохицуулалт байхгүй байна.

- Захиргааны хяналтын хувийн хэрэг хөтлөх нэгдсэн загвар байхгүйгээс нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, хэлтсүүд өөр өөр маягт боловсруулан мөрдөж байна.
- Мөн хэт удаан хугацаагаар хяналт тогтоох нь тухайн хүнийг залхаах, хяналтын ач холбогдлыг сулруулах, хэлбэрдэх шинжтэй болох сөрөг үр дагавар үүсгэж байна.

Захиргааны хяналтад байгаа хүмүүстэй ярилцсан тэмдэглэлээс...

Цагдаагийн байгууллагаас тавьж буй хяналтын хүрээнд сард нэг удаа хорооны хэсгийн байцаагч дээр очиж бүртгүүлэх журмаар уулздаг, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй гэсэн баталгаа гаргаж өгдөг, зарим баяр ёслолын үеэр бидэнд итгэлийн хуудас, мэдэгдэл өгдөг, гэмт хэрэг үйлдэхгүй байх талаар хууль, эрх зүйн зөвлөгөө өгдөг. Уулзах цаг хугацаагаа хороо хариуцсан хэсгийн байцаагчтай тохирдог тул ажил хийхэд, амьдрахад саад бэрхшээл учраад байдаггүй, харин сэтгэлзүйн хувьд заримдаа дарамттай санагддаг.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид төрийн байгууллагаас хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, тэдгээрийг нийгмийн харилцаанд дасан зохицох, хэвийн ажиллаж амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилт дэвшүүлсэн ч хэрхэн хэрэгжүүлэх талаар зохицуулалт байхгүй, дан ганц

цагдаагийн байгууллага дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр л хяналт тавьж байна.

- НҮБ-ын зөвлөмж, батлагдсан олон улсын сайн туршлагаас үзэхэд хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих хяналтын асуудал нь тун чухал хэдий ч уламжлалт хандлага буюу “зөвхөн цагдаагийн хариуцах асуудал” гэсэн өнцгөөр харах нь хангалтгүй, үр дүнгүй болох нь нотлогдсон билээ.
- Хорооны хэсгийн байцаагч, нийгмийн ажилтнуудаас авсан судалгаанд холбогдох төрийн байгууллагуудын ачаалал их, хоорондын уялдаа холбоо хангалтгүй, алба хаагчдын тоо хүрэлцээгүй, ялангуяа төрийн захиргааны байгууллагын ажилтнууд нь сонгуулийн үр дүнгээс шалтгаалан ажлын байран дээрээ тогтвор суурьшилтай ажиллаж чаддаггүй зэрэг бэрхшээл тоочжээ. Мөн нийгмийн ажилтан нь ихэвчлэн хорооны нэг цэгийн үйлчилгээний танхимд нийтийн дунд ажилладаг тул хорихоос суллагдсан этгээд тэр бүр зовлон гачигдлаа ярилцаж, тулгамдаж буй асуудлаа шийдүүлэх боломж хомс болохыг тодотгосон.
- Энэ бүхнээс дүгнэхэд захиргааны хяналт тун хязгаарлагдмал хүрээнд хийгдэж байна. Тиймээс хорихоос суллагдсан этгээдүүдийг эргэн нийгэмших, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан

сэргийлэх цогц үйл ажиллагаа болж чаддаггүй. Тухайлбал, 2000-2009 онд урьд нь шүүхээр ямар нэгэн хэлбэрээр ял шийтгэгдсэн 18,117 хүн дахин гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэ нь нийт гэмт этгээдийн 10 хувьтай тэнцэж байна.

- Хоригдож буй болон хорихоос суллагдаад хяналтад байгаа этгээдүүдийн хувьд гол бэрхшээл нь нийгмийн хүрээлэл байхгүй, өөрийн гэсэн гэр оронгүй, тодорхой эрхэлсэн ажил, орлогогүй, ажилд авдаггүй, төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн аливаа төсөл арга хэмжээнд хамрагдаж чаддаггүй, хорихоос суллагдсаны дараа олгодог нэг удаагийн тусламжийг ч авч чаддаггүй зэрэг нийтлэг тулгамдсан асуудал байна. Үүний зэрэгцээ, одоо хэрэгжүүлж буй захиргааны хяналт нь нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх гэхээсээ илүүтэй, залхаан цээрлүүлэлтийн арга хэмжээ болж, сэтгэл зүйн дарамтад оруулж байна хэмээн судалгаанд оролцсон хүмүүс хариулжээ.
- Хорихоос суллагдсаны дараа олгодог нэг удаагийн тусламж өгөх эсэхийг амьжиргааны түвшин тогтоох судалгаанд тулгуурлан явуулдаг бөгөөд уг судалгааны асуумж нь бодит байдалд нийцэхгүй байгаагийн улмаас тэтгэмжид хамрагдах шаардлагатай ихэнх хүмүүс мөнгөн олговор авч чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

- Хорихоос суллагдсаны дараа төрийн захиргааны байгууллагын дэргэд эсхүл мэргэшсэн төрийн бус байгууллагын оролцоотой хууль эрх зүйн болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бичиг баримтжуулах, ажилд зуучлах зэрэг бүх төрлийн үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулах төвийг аймаг, дүүрэг бүрт байгуулах;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийн санал санаачилгыг дэмжих, аливаа үйл ажиллагаа нь иргэд олон нийтийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтран ажиллахад анхаарах;
- Хорихоос суллагдсан этгээдэд амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааны дагуу олгогдож буй нэг удаагийн тэтгэмжийг ялгаваргүйгээр олгох;
- Дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх, хууль эрх зүй, сэтгэл заслын болоод мэргэжил олгох сургалтуудад тогтмол хамруулах ажлыг нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Нутгийн захиргааны байгууллагуудын эрх хэмжээ, үүрэг, оролцоог нарийвчлан тодорхойлох, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг дахин нарийвчлан боловсруулснаар чиг үүргийн давхардал хийдлийг арилгах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах, хамтран мэдээлэл солилцох, нэгдсэн бүртгэлийн сантай байх боломж бололцоог бий болгох;
- Төрийн захиргааны албан хаагчид, тэр дундаа хороодын нийгмийн ажилтнуудыг ажлын байрны таатай нөхцөл боломжоор хангах, иргэдтэй уулзах, тэдгээрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нэг цонхны үйлчилгээний танхимд бус тусад нь уулздаг өрөөтэй болгох, ажлын байран дээр тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Захиргааны хяналтын хувийн хэргийн нэгдсэн загвар, маягт батлах;
- Хорих ял эдлээд суллагдсан этгээдийг гэм буруугаа ухамсарласан эсэх, эргэн нийгэмшсэн байдлыг үнэлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах замаар захиргааны хяналтын хугацааг тодорхойлдог байх.